



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 284

Улаанбаатар хот

Г “Цогт жанчхүү” хоршооны хадгаламж, 7
зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг
хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Цогтжанчхүү” хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2011 оны 9 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.
2. Хоршооны хадгаламж, зээлийн үлдэгдэл, төлбөр тооцоог барагдуулахыг “Цогтжанчхүү” хоршоо/Т.Нанжидсүрэн/-нд үүрэг болгосугай.
3. Тус хоршоотой холбоотой этгээдүүдийг шаардлагатай мэдээллээр хангаж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар/Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газарт тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН